



ASIA RUGBY SEVENS
TROPHY JAKARTA 2019



UZB 0 v 19 MGL

MEN POOL A



2019

МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБОО
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Азийн Рагби 7
Цомын АШТ ЖАКАРТА

Монгол – Тайвань
Нөхөрсөг тоглолт

Их, дээд сургууль
Рагби 7 АШТ

МРХ-НЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

Нэг. Сургалт семинар зохион байгуулсан байдал

1. Нийслэлийн Налайх дүүргийн ЕБС-ийн багш нарын сургалт
2. Рагбид оролцох нь хөтөлбөрийн сургалт /Сэлэнгэ аймаг, Цагааннуур сум/
3. Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалт /Сэлэнгэ аймаг, Баянгол сум/
4. Шүүгчийн сургалт

Хоёр. Тэмцээн уралдаан зохион байгуулсан байдал

1. Улаанбаатарын өвлийн наадам
2. Цасны рагби 2019 АШТ
3. ЕБС-иудын Точ рагбигийн АШТ
4. Бээжин аялан тоглолт
5. Рагби 7 УАШТ
6. Их, дээд сургуулиудын Рагби 7 төрлийн анхдугаар УАШТ
7. Азийн Рагби 7 Цомын АШТ /Индонез улс, Жакарта/
8. Монгол – Тайвань нөхөрсөг тоглолт
9. Рагби 15 УАШТ

Гурав. Хамтын ажиллагаа

1. Японы ЗГ-ын JENESYS 2.0 хөтөлбөрт МРХ-ны залуу тамирчдаа хамрууллаа
2. Азийн Рагбид оролцох нь хөтөлбөрийн чуулга уулзалтад оролцлоо
3. АРХ-ны хагас жилийн хуралд УЗ-ийн гишүүд оролцов
4. ДРХ-ны чуулга уулзалт Япон улсад боллоо
5. Японы шигшээ багийн ахлагч Майкл Лийтчийн санаачлагаар шинэ залуу тамирчин бэлтгэхээр боллоо
6. ДАШТ-ний нээлтийн арга хэмжээнд тамирчдаа оролцуулав
7. ДАШТ-ийг SPS TV-ээр шууд дамжуулан хүргэлээ

Дөрөв. Бусад хийгдсэн ажлууд

1. Япон улсад суралцах Д.Норовсамбуугийн аяллын тэмдэглэл баримтат киног бүтээлээ
2. Монгол – Тайвань нөхөрсөг тоглолтыг МҮОНРТ-ээр орон даяар шууд дамжуулав

СУРГАЛТ СЕМИНАР

Нийслэлийн Налайх дүүргийн ЕБС-ийн багш нарын сургалт

МРХ-ны сургалтын албанаас Налайх дүүргийн ЕБС-ийн биеийн тамирын багш нарт рагбигийн багш дасгалжуулагч бэлтгэх сургалтыг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тус сургалтыг Нийслэлийн Боловсролын Газартай хамтран зохион байгуулсан бөгөөд нийслэлээс алслагдсан дүүрэгт болсноороо онцлогтой юм.

Сургалтыг МРХ-ны сургагч багш Л.Загдсүрэн, Г.Хосбаяр нар удирдан явуулсан ба сургалт онол болон дадлагын хэсгээс бүрдсэн юм.



Сургалтанд хамрагдсан багш нар



Рагбид оролцох нь хөтөлбөрийн сургалт **/Сэлэнгэ аймаг, Цагааннуур сум/**



Дэлхийн Рагбигийн Холбооны шинэ залуу тамирчдыг төрөн гаргахад онцгой ач холбогдолтой Рагбид оролцуулах нь /Get Into Rugby/ хөтөлбөр нь манай улсад хэрэгжээд 5 жил болсон байна.

Рагбид оролцох нь хөтөлбөрийн сургалтыг монгол орны хойд хилийн сум болох Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр ЕБС-ийн сурагчдад амжилттай танилцууллаа.



Сургалтын хэсгээс

Бид энэ хугацаанд 15 хүүхдийн зуслангийн, нийслэлийн 7 дүүргийн, аймаг сумдын 4 байршилд нийтдээ 20 мянга гаруй хүүхэд залуусыг хамруулаад байна.



Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ЕБС-ийн ахлах ангийн 6 бүлгийн 6 багш, 120 гаруй сурагчид хамрагдаж 3 ээлжээр рагбигийн бэлтгэлтэй танилцан бэлтгэлд оролцож гараагаа эхлүүллээ.

Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалт **/Сэлэнгэ аймаг, Баянгол сум/**



Рагбид оролцох нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч анхны орон нутаг бол Сэлэнгэ аймгийн Баянгол /Баруунхараа/ сумын ЕБСургууль юм. Хөтөлбөр 2019 оны 4 дүгээр сарын 29-нд зохион байгуулагдаж Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш дасгалжуулагч бэлтгэх сургалт болон өдөрлөгийг 8 багш, дунд болон ахлах ангийн 8 бүлгийн 120 гаруй сурагчдыг оролцууллаа.

Баянгол сумын ЕБС-ийн Англи хэлний багш Г.Цэцэгсайхан болон Хөх Толбот Дайчид РК-ын менежер Б.Пүрэвбат нар удирдан явуулдаг.

МРХ-ны 2019 оны ЕБС-иудын Точ рагбигийн АШТ-нд анх удаагаа баг тамирчдаа бэлтгэн оролцуулж чадсан нь сайшаалтай юм.



Рагбигийн бэлтгэлийн хэсгээс



*ЕБС-иудын Точ рагбигийн АШТ-ий
“Баянгол” охидын багийн тоглолт*

Шүүгчийн сургалт



МРХ нь Дэлхийн Рагбигийн Холбооны сургалтуудыг зохион байгуулах бүрэн эрхтэй болсон билээ. Мөн бид дотоодын тэмцээн уралдааныг шүүх шүүгчдийн сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтыг МРХ-ны шүүгчдийн зөвлөлийн ахлах Г.Хосбаяр удирдан МРХ-ны гишүүн клубүүдийн 10 залуу шүүгчдийг хамрууллаа.

Эдгээр шүүгчид нь МРХ-ны Өсвөрийн тэмцээн уралдааныг шүүхээр бэлтгэгдэж байгаа ба цаашлаад дотоодын насанд хүрэгчдийн тэмцээнийг шүүх эрхээ олж авах юм.

Сургалтанд хамрагдсан шүүгчдийн нэрс:

- | | |
|-------------------|------------------------|
| 1. О.Нацагдорж | /Анхдагч Чононууд РК/ |
| 2. Г.Мөнхбэмбэрэл | /Анхдагч Чононууд РК/ |
| 3. Д.Алтансоёмбо | /Анхдагч Чононууд РК/ |
| 4. Ү.Уранзангиа | /Хөх Толбот Дайчид РК/ |
| 5. М.Цогт-Эрдэнэ | /Хан-Уул РК/ |
| 6. Б.Дэлгэрмаа | /Хан-Уул РК/ |
| 7. Б.Мандах | /Ангууч Арслангууд РК/ |
| 8. С.Дарханбат | /Анхдагч Чононууд РК/ |
| 9. Б.Батчимэг | /Чийтас РК/ |
| 10. Н.Төгөлдөр | /Ирвэсүүд РК/ |



ТЭМЦЭЭН УРАЛДААН

Улаанбаатарын өвлийн наадам



Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын дэмжлэгтэйгээр өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор гурав дахь жилдээ зохион байгуулсан “Улаанбаатарын өвлийн наадам”-д Монголын Рагбигийн Холбоо 3 дахь жилдээ хамтран ажиллаж Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

2019 онд зохион байгуулагдсан Улаанбаатар хотын Цасны Точ рагбигийн аварга шалгаруулах гурав дахь удаагийн тэмцээнд нийт 10 холимог багийн дунд 3 бүсэд хуваан тойргийн тоглолтоор тоглож чансаагаараа тэргүүлсэн багууд хоорондоо тоглон Кап, Плайт, Боул гэсэн цом болон алт, мөнгө, хүрэл медалийн төлөө өрсөлдсөн юм.



Тэмцээний хэсгээс



Тэмцээнд оролцсон нийт баг тамирчид

Тэмцээний шагнал хүртсэн байдал:

1. Хүрэл медалийг ҮБХИС-ийн О.Гантулга дасгалжуулагчтай 1-р баг хүртлээ.
2. Мөнгөн медалийг Г.Өлзийсайхан ахлагчтай Хан-Уул рагби клубын баг тамирчид хүртлээ.
3. Аваргын цом, алтан медалийг Хөх Толбот Дайчид рагби клуб хүртэж шилжин явах цомыг хүртлээ.



Шагнал гардуулах ёслолын ажиллагаа

Улаанбаатарын өвлийн наадам 2019 арга хэмжээнд нийт 10 багийн 150 гаруй тамирчид оролцсон бөгөөд шинээр ХААИС, ҮБХИС-ийн багууд оролцож өрсөлдөөнийг нэмж, амжилттай оролцлоо.

Цасны рагби 2019 АШТ

МРХ-ны 7 дахь удаагийн Цасны рагби АШТ 2019 оны 3 дугаар сарын 2-оос эхлэн 4 долоо хоногийн турш эрэгтэйчүүдийн 2 дивизоны 7 багийн 150 гаруй, эмэгтэйчүүдийн 5 багийн 100 гаруй тамирчдыг хамруулж чадсан чансаа өндөр тэмцээн болсон билээ.

Энэ жилийн тэмцээн маш онцлог болсон бөгөөд цаг агаарын дулаарал мөн цас ороогүй нь Цасны рагбигийн түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болж үлдэж байна.

Бидний хамтын ажиллагаа жил бүр өсөн нэмэгдэж байгаа билээ. 7 дахь удаагийн Цасны рагбигийн АШТ-ийг бэртэл гэмтэлгүй амжилттай зохион байгуулахад Олон улсын дунд сургууль дэмжлэг үзүүлэн хамтран ажилласныг дуулгахад таатай байна.



Тэмцээний нээлт

Цасны рагби 2019 АШТ-ий нээлтийн үеэр Японы шигшээ багийн ахлагч Майкл Лийтч оролцож, тамирчдад амжилт хүсэн Япон улсад 3 жилийн тэтгэлэгтэй суралцуулах 15 настай монгол хүүг сонгосон юм.



Тэмцээний нээлтэнд оролцсон зочид төлөөлөгчид



Тоглолтын зурагнуудаас

Тэмцээний байр эзэлсэн байдал:

Эмэгтэйчүүдийн тоглолт

- 1 дүгээр байр ҮБХИС-ийн Чийтас РК
- 2 дугаар байр Хөх Толбот Дайчид РК
- 3 дугаар байр Аварга Зөгийнүүд РК
- 4 дүгээр байр Хан-Уул РК
- 5 дугаар байр Анхдагч Чононууд РК

Эрэгтэйчүүдийн тоглолт

Дивизон 2

- 1 дүгээр байр ҮБХИС-ийн Чийтас РК
- 2 дугаар байр Аварга Зөгийнүүд РК
- 3 дугаар байр Ирвэсүүд РК

Дивизон 1

- 1 дүгээр байр Ангууч Арслангууд РК
- 2 дугаар байр Хан-Уул РК
- 3 дугаар байр Хөх Толбот Дайчид РК
- 4 дүгээр байр Анхдагч Чононууд РК



ЕБС-иудын Точ рагбигийн АШТ

Монголын Рагбигийн Холбооноос зохион байгуулдаг өсвөрийн тамирчдад зориулсан ЕБС-иудын дундах Точ рагбигийн АШТ Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнгийн хөлбөмбөгийн талбайд 2019 оны 5 дугаар сарын 11-12-ны хооронд зохион байгуулагдлаа.

Энэ удаагийн тэмцээнд нийслэлийн болон хөдөө орон нутгийн 8 ЕБСургуулийн 8 эрэгтэй баг, 7 эмэгтэй багууд хурд хүч, авхаалж самбаагаа сорьсон юм.



Төрийн дуулал, торгон мөч

2019 оны Точ рагбигийн АШТ-нд анх удаагаа хөдөө орон нутгаас Сэлэнгэ аймгийн Баянгол сумын өсврийн баг тамирчид оролцсон нь тэмцээнийг улам сонирхолтой болгосон юм.

Точ рагбигийн АШТ-нд оролцсон сургуулиудын жагсаалт:

1. Буянт-Ухаа Цогцолбор сургууль
2. Аварга лицей сургууль
3. Монгол-Коосэн сургууль
4. Ирээдүй Цогцолбор сургууль
5. 72 дугаар сургууль
6. Баянгол сургууль /Сэлэнгэ аймаг Баянгол сум/
7. 102 дугаар сургууль
8. Амгалан Цогцолбор сургууль



Хэсгийн тоглолтууд

Точ рагбигийн АШТ-ий байр эзэлсэн байдал:

Охидын багууд

1. Алтан медаль Монгол-Коосэн сургууль
2. Мөнгөн медаль Буянт-Ухаа Цогцолбор сургууль
3. Хүрэл медаль 72 дугаар сургууль

Хөвгүүдийн багууд

1. Алтан медаль Буянт-Ухаа Цогцолбор сургууль
2. Мөнгөн медаль Аварга лицей сургууль
3. Хүрэл медаль Монгол-Коосэн сургууль



Алтан медаль хүртсэн баг тамирчид

Точ рагбигийн АШТ-ий эрэгтэй шилдэг тоглогчоор Буянт-Ухаа цогцолбор сургуулийн Т.Пүрэвбаяр, эмэгтэй шилдэг тоглогчоор Монгол-Коосэн сургуулийн Б.Оюунзул нар шалгарсан юм.

Бээжин аялан тоглолт

МРХ нь клубүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, гадаад харилцааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд БНХАУ-ын Бээжин хотын рагбигийн клуб, холбоодтой хамтын ажиллагааг эхлүүлсэн билээ.

“Бээжин аялан тоглолт”-нд МРХ-ны гишүүн клубүүдийн нийт 38 /25 эрэгтэй, 13 эмэгтэй/ тамирчны бүрэлдэхүүнтэй амжилттай оролцсон. Эрэгтэй баг тамирчид Хан-Уул РК-ын нэрэн дор багаа бүрдүүлсэн бол эмэгтэй баг тамирчид Хөх Толбот Дайчид РК-ын нэрэн дор баг тамирчдаа бүрдүүлсэн юм.

Тус аялан тоглолт нь монголын рагбигийн клубүүдийн анхны бие даасан түр тэмцээн бөгөөд эмэгтэй баг тамирчид маань анхны олон улсын тэмцээнээ эхлүүлсэн ач холбогдолтой болж чадсан.



Тэмцээний зургаас

Эмэгтэй баг тамирчид маань Рагби 10 төрлөөр өрсөлдөн нийт 3 тоглолтыг хийж анхны хожлоо Бээжин хотын Аардваркс клубыг хожиж анхны ялалтаа авсан.

Хан-Уул РК Бээжин хотын рагбигийн клубын эсрэг тоглолт хийж маш өрсөлдөөнтэй тоглолтыг үзүүлсэн. Мөн эрэгтэй баг тамирчид Олимпийн төрлөөр /Рагби 7/ тоглож аялан тоглолтоо үргэлжлүүлэн амжилттай тэмцээнээ дуусгасан билээ.





Монголын эмэгтэй баг тамирчид



Тоглолт сайхан боллоо



Мөргөлтийг сайн хийлээ



Трай!!!

Рагби 7 УАШТ

МРХ-ны 8 удаагийн Рагби 7 УАШТ 6 дугаар сарын 8-нд МҮОХ-ны дэргэдэх Бейсболын талбайд зохион байгуулагдсан. Тэмцээнд хамгийн олон баг буюу эрэгтэй 8 баг, эмэгтэй 6 багийн нийт 200 гаруй тамирчид оролцож аваргуудаа тодруулсан юм.



Багийн ахлагч нарын зураг

Тэмцээнд оролцсон багийн нэрс:

Эрэгтэй баг

Ангууч Арслангууд РК
Хан-Уул РК
Хөх Толбот Дайчид РК
Анхдагч Чононууд РК
Аварга Зөгийнүүд РК
Ирвэсүүд РК
Чийтас РК
084 дүгээр анги

Эмэгтэй баг

Хан-Уул РК
Хөх Толбот Дайчид РК
Анхдагч Чононууд РК
Аварга Зөгийнүүд РК
Ирвэсүүд РК
Чийтас РК

Тэмцээний эмэгтэйчүүдийн медаль хүртсэн байдал:

- | | |
|------------------|----------------------|
| 1. Алтан медаль | ҮБХИС-ийн Чийтас РК |
| 2. Мөнгөн медаль | Хөх Толбот Дайчид РК |
| 3. Хүрэл медаль | Хан-Уул РК |

Тэмцээний эрэгтэйчүүдийн медаль хүртсэн байдал:

- | | |
|------------------|----------------------|
| 1. Алтан медаль | Ангууч Арслангууд РК |
| 2. Мөнгөн медаль | ҮБХИС-ийн Чийтас РК |
| 3. Хүрэл медаль | Анхдагч Чононууд РК |

Азийн Рагби 7 Цомын АШТ /Индонез улс, Жакарта/

Монголын Рагби 7 шигшээ баг 2019 оны 8 дугаар сарын 10-11-ий өдрүүдэд Индонез улсын Жакарта хотод болсон Ази тивийн Рагби 7 төрлийн Цомын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож шагналт 4 дүгээр байр эзэлсэн.

Манай шигшээ багийн хувьд 2010, 2011 онуудад зохиогдож байсан Азийн Спортын Их Наадам, Шанхайн Рагби 7 цувралуудад оролцож Рагби 7 буюу Олимпийн төрлийн гараагаа эхлүүлж байсан түүхтэй билээ.



Хэсгээсээ 1 дүгээр байраар шалгарлаа

Бид 8 жилийн дараа эргэн ирж Ази тивийн Рагби 7 Цомын аварга шалгаруулах тэмцээнд оролцож чансаагаа ахиулж хэсгээсээ Узбекистаны шигшээ багийг 19-0, Индонезийн шигшээ багийг 12-19 онооны харьцаатайгаар хожин 1 дүгээр байраар шалгарсан.



Хагас шигшээ тоглолт



Хүрэл медалийн мөлөөх тоглолт

Аваргын цомны төлөөх хагас шигшээ тоглолтонд Малайзын шигшээ багтай тоглож 26-0 харьцаатайгаар хожигдож хүрэл медалийн мөлөө Тайланд шигшээ багтай тоглон 14-24 гэсэн онооны харьцаатайгаар хожигдож шагналт 4 дүгээр байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн билээ.



Ази тивийн Рагби 7 Цомын АШТ-нд оролцсон Монголын улсын шигшээ бгг

Шигшээ баг маань 2019 оны 5 дугаар сараас эхлэн бэлтгэлээ базааж эхэлсэн бөгөөд шигшээ багийн дасгалжуулагчаар МРХ-ны дэд ерөнхийлөгч Г.Дашдэндэв /ОУХМ/ ажиллаж баг тамирчдаа энэ амжилтанд хүргэсэн билээ.

Шигшээ багийн бүрэлдэхүүнд Рагби 15 төрлийн шигшээ багийн тамирчид болон шинэ залуу тамирчид багтсан бол эмчээр Т.Өнөржаргал ажилласан юм.



Багийн ахлагч Б.Наранбаатар



Н.Отгонбаяр довтолгоонд

Шигшээ багийн тамирчдын нэрс:

Б.Наранбаатар /Багийн ахлагч, ОУХМ/
Э.Гансайхан /ОУХМ/
П.Баярням /ОУХМ/
Г.Жавхланбаяр /ОУХМ/
Н.Отгонбаяр /СМ/
С.Банзрагч /СМ/

Г.Мэнд-Амар /СМ/
Б.Бат-Эрдэнэ /СМ/
Б.Сод-Эрдэнэ /СДМ/
Н.Хорлоо
Г.Шижир-Эрдэнэ
Б.Майдар

Их, дээд сургуулиудын Рагби 7 төрлийн анхдугаар УАШТ



Монголын Рагбигийн Холбооноос их, дээд сургуулиудын дунд Анхдугаар Рагби 7 төрлийн аварга шалгаруулах тэмцээнийг 9 дүгээр сарын 14-ний өдөр Бейсболын талбайд зохион байгуулсан.

Тус тэмцээнийг DHL олон улсын буухиа шуудангийн компани ивээн тэтгэж хамтран ажилласан бөгөөд оюутан залуусыг олимпын төрлийн спортоор хичээллэхэд урам зориг өгсөн маш сайхан өрсөлдөөнтэй тэмцээн болсныг онцолж байна.

Их дээд сургуулиудын Анхдугаар Рагби 7 АШТ-нд:

1. Аварга Дээд Сургууль
2. Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль
3. Дотоод Хэргийн Их Сургууль
4. Монгол Коосэн Технологийн Коллеж
5. Их Засаг Их Сургуулийн 5 эрэгтэй, 4 эмэгтэй багийн 200 тамирчин оролцож аваргаа тодруулсан юм.



Их, дээд сургуулийн анхдугаар АШТ-ий эмэгтэйчүүдийн медаль хүртсэн байдал:

- | | |
|------------------|----------------------------------|
| 1. Алтан медаль | ҮБХИС-ийн Чийтас РК |
| 2. Мөнгөн медаль | ИЗИС |
| 3. Хүрэл медаль | Монгол Коосэн Технологийн Коллеж |



Тэмцээний хэсгээс

Их, дээд сургуулийн анхдугаар АШТ-ий эрэгтэйчүүдийн медаль хүртсэн байдал:

- | | |
|------------------|----------------------|
| 1. Алтан медаль | Аварга Дээд Сургууль |
| 2. Мөнгөн медаль | ҮБХИС-ийн Чийтас РК |
| 3. Хүрэл медаль | ИЗИС |



ҮБХИС-ийн хурдан довтолгоо



ИЗИС-ийн эмэгтэй багийн довтолгоо

Анхдугаар ИДС-ийн Рагби 7 АШТ-ий шилдэг эмэгтэй тоглогчоор ҮБХИС-ийн А.Ариунаа, шилдэг эрэгтэй тоглогчоор Аварга Дээд сургуулийн Б.Сод-Эрдэнэ нар тодорч ивээн тэтгэгч DHL ХХК-ий гарын бэлгийг хүртсэн.

Монгол – Тайвань нөхөрсөг тоглолт

Монголын Рагбигийн Холбоо нь 2019 онд анх удаагаа Ази тив, Япон улсад зохион байгуулагдсан Рагбигийн 9 дэх удаагийн ДАШТ-ийг угтан Монгол улсад анхны олон улсын албан ёсны тоглолтыг Тайваний шигшээ багтай 2019 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Төв Цэнгэлдэх Хүрээлэнд зохион байгууллаа.



Энэхүү “Монгол-Тайвань” Рагби фестивал 2019 арга хэмжээг МҮОНРТ-ийн Спорт сувгаар /MNB Sport HD Facebook Page/ орон даяар, мөн МРХ-ны албан ёсны /Mongolian Rugby Football Union/ хуудсаар шууд дамжуулан хүргэлээ.



Нэмэлт өшиглөлт амжилттай



Лайн-Аутын өрсөлдөөн

Рагби фестивал 2019 арга хэмжээнд мөн БНХАУ-ын Бээжин хотын рагбигийн Аардваркс клубын эмэгтэй зочилж, монголын эмэгтэй баг тамирчидтай нөхөрсөг тоглолтыг хийж эмэгтэйчүүдийн рагбигийн хөгжлийг спорт сонирхогч болон үзэгчдэд харуулж чадсан.



Эмэгтэй багуудын тоглолтонд Хөх Толбот Дайчид РК, Чийтас РК болон Бээжингийн Аардваркс РК-үүд тойргийн системээр өрсөлдөж ҮБХИС-ийн Чийтас РК 2 хожин аваргын цомыг хүртсэн бол Хөх Толбот Дайчид РК 1 хожил 1 хожигдолтойгоор 2 дугаар байр эзэлсэн бол зочин Аардваркс РК 2 хожигдолтойгоор 3 дугаар байрт орсон юм.



Тэмцээний сонирхолтой мөчүүдээс





Ялалтын дараа, Монгол 19-17 Тайвань

Рагби фестивал 2019 арга хэмжээний гол тоглолт маш ширүүн өрсөлдөөнтэй болсон бөгөөд 14 дэх минутад Монгол улсын шигшээ багийн тамирчин Э.Гансайхан /ОУХМ/ бөмбөгийг тасалж эхний Трайг авч, өөрөө нэмэлт өшиглөлтийг хийж 7-0 болгосон юм.

Үүнээс хойш 16 дахь минутад Тайваний шигшээ багийн Ли Хонг Ан жигүүрээр довтолж Трай авч 7-5 болголоо.

Монголын урд эгнээний хүчтэй довтолгоо үргэлжилж 20 дахь минутад Д.Баярманлай /ОУХМ/ ээлжит Трай авч, нэмэлт өшиглөлтийг Э.Гансайхан /ОУХМ/ амжилттай хийж тооны харьцааг 14-5 болгон холдуулсан юм.

Тайваний шигшээ баг 1 дүгээр үеийн сүүлийн минутад оноог ойртуулан Лий Чей Жун Трай авлаа. Нэмэлт өшиглөлтийг Ву Чих Ий оруулж 14-12 болгож өрсөлдөөнийг улам нэмсэн юм.

Монголын шигшээ багийн хурдан довтолгоогоор Б.Бат-Эрдэнэ /СМ/ 63 дахь минутад Трай авч 19-12 болгон холдууллаа.

Тайваний шигшээ багийн довтолгоо хурдтай үргэлжилж 74 дэх минутад Чен Кай Юүн Трай авч багийнхаа оноог 19-17 болгож тоглолтыг өндөрлүүлсэн билээ.



Манай скрам хүчтэй байлаа



Тэмцээний цомыг гардуулах мөч

“Монгол Тайвань рагби фестивал 2019” наадмыг БСШУСЯ, БХЯ-ны зочид төлөөлөгчид, ИБУИНВУ-ын Элчин сайд, Австрали улсын Элчин сайд, АНУ-ын Элчин сайд, Тайваний төлөөлөгчийн газрын зочид төлөөлөгчид болон рагбигийн хөгжөөн дэмжигчид үзэж сонирхсоныг дуулгахад таатай байна.



Анх удаагаа олон улсын буюу албан ёсны шигшээ багийг хүлээн авсан энэхүү “Монгол Тайвань” арга хэмжээг амжилттай зохион байгуулахад ерөнхий ивээн тэтгэгчээр Aspire Mining LLC, DHL LLC, Betastar LLC, Starchase Automotive Limited LLC компаниуд хамтран ажиллаж энэхүү түүхэн ялалтанд хүргэсэн нийт ивээн тэтгэгч, дэмжигчид та бүхэндээ нийт баг тамирчдынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна.



Рагби 15 УАШТ

Монголын Рагбигийн Холбооны 2019 оны эрэгтэйчүүдийн Рагби 15, эмэгтэйчүүдийн Рагби 10 төрлийн УАШТ 2 долоо хоногийн турш амжилттай болж өндөрлөсөн. 7 дахь удаагийн УАШТ-нд хамгийн олон баг оролцож байгаа бөгөөд эрэгтэй төрөлд дивизон 1-д 4 баг, дивизон 2-т 3 баг, эмэгтэйчүүдийн тэмцээнд 5 эмэгтэй баг өрсөлдлөө.

Тэмцээний эхний 7 хоногийн тоглолтууд Бейсболын талбайд явсан бол төгсгөлийн тоглолтууд Үндэсний Цэнгэлдэх Хүрээлэнгийн талбайд бэртэл гэмтэлгүй явагдсан болно.

1 дэх долоо хоногийн үр дүн:

Эмэгтэй тоглолтууд

1. Хөх Толбот Дайчид РК 54-5 Ирвэсүүд РК
2. Анхдагч Чононууд РК 0-27 ҮБХИС Чийтас РК
3. Хан-Уул РК 46-0 Ирвэсүүд РК
4. Хөх Толбот Дайчид РК 12-19 ҮБХИС Чийтас РК
5. Хан-Уул РК 15-10 Анхдагч Чононууд РК



2019 оны Рагби 10 УАШТ-ий аварга ҮБХИС-ийн Чийтас РК

Эрэгтэй тоглолтууд

Дивизон 2

1. Ирвэсүүд РК 25-19 Спартанс /ИЗОУИС/

Дивизон 1

1. Анхдагч Чононууд РК 34-30 Хөх Толбот Дайчид РК
2. Хан-Уул РК 46-12 Ангууч Арслангууд РК

2 дахь долоо хоногийн үр дүн:

Эмэгтэй тоглолтууд

1. Хан-Уул РК 0-25 ҮБХИС Чийтас РК
2. Хөх Толбот Дайчид РК 52-0 Анхдагч Чононууд РК
3. Хан-Уул РК 15-15 Хөх Толбот Дайчид РК



Рагби 15 УАШТ-ий Дивизон 2-н аварга ҮБХИС-ийн Чийтас РК

Эрэгтэй тоглолтууд

Дивизон 2

1. Спартанс РК /ИЗОУИС/ 24-52 ҮБХИС Чийтас РК
2. ҮБХИС Чийтас РК 34-22 Ирвэсүүд РК

Дивизон 1

1. Ангууч Арслангууд РК 41-29 Хөх Толбот Дайчид РК /Хүрэл медалийн тоглолт/
2. Хан-Уул РК 39-34 Анхдагч Чононууд РК /Алтан медалийн тоглолт/



Рагби 15 УАШТ-ий Дивизон 1-н аварга Хан-Уул РК

2019 оны УАШТ-ий шилдэг тамирчдаар:

Дивизон 1 Хан-Уул РК ахлагч П.Баярням

Дивизон 2 ҮБХИС Чийтас РК тамирчин Ш.Ганболд

Шилдэг эмэгтэй тамирчин ҮБХИС Чийтас РК У.Дэжидмаа нар шалгарсан юм.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Японы ЗГ-ын JENESYS 2.0 хөтөлбөрт MPX-ны залуу тамирчдаа хамрууллаа

Япон улсын Засгийн газрын JENESYS 2.0 хөтөлбөрт 2018 оны MPX-ны Өсөх ирээдүйтэй тамирчдаар шалгарсан Хан-Уул РК-ын тамирчин Б.Сод-Эрдэнэ, Хөх Толбот Дайчид РК-ын тамирчин Ү.Уранзангиа нар оролцож, Япон улсын түүх соёл, аж амьдрал, зан заншил, техник технологийн өндөр хөгжилтэй танилцлаа.



Азийн Рагбид оролцох нь хөтөлбөрийн чуулга уулзалтад оролцлоо

Малайз улсын Куала Лумпур хотноо 7 дугаар сарын 4-8-ны хооронд болсон Ази тивийн рагбигийн хөгжлийн чуулга уулзалтанд MPX-ны Гүйцэтгэх захирал Н.Энх-Амгалан оролцлоо. Тус чуулга уулзалт нь Рагбид оролцох нь хөтөлбөрийн хэрэгжилтээ дүгнүүлэх, цаашдын чиглэл зорилгоо тодорхойлох өндөр ач холбогдолтой байсан юм.



APX-ны жилийн эцсийн хуралд УЗ-ийн гишүүд оролцов



МРХ нь Азийн Рагбигийн Холбоотой нягт хамтын ажиллагааны хүрээнд APX-ны жилийн эцсийн хуралд Удирдах зөвлөлийн гишүүн Д.Гансүх оролцож APX-ны ерөнхийлөгчийг сонгох сонгуульд оролцоод ирсэн.



ДРХ-ны чуулга уулзалт Япон улсад боллоо

Япон улсад зохион байгуулагдсан ДРХ-ны Чуулга уулзалтанд МРХ-ны Ерөнхийлөгч Ч.Мөнхбат, Тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Дашдэндэв нар оролцож, Дэлхийн Рагбигийн гишүүнчлэлээ ахиулах чухал ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.



Японы шигшээ багийн ахлагч Майкл Лийтчийн санаачлагаар шинэ залуу тамирчин бэлтгэхээр боллоо



Японы рагбигийн шигшээ багийн ахлагч Майкл Лийтчийн санаачлагаар Монгол улсаас 15 настай хүүг 3 жилийн хугацаатай сургаж, рагбигийн тамирчин болгохоор Буянт-Ухаа Цогцолбор сургуулийн сурагч Д.Норовсамбууг сонгон шалгарууллаа. Д.Норовсамбууг 2019 оны ДАШТ-ий нээлтийн тоглолтонд урьж биечлэн уулзан суралцах сургуультай нь танилцууллаа.

Майкл Лийтч нь Шинэ Зеланд гаралтай бөгөөд 15 настайд Япон улсад тэтгэлэгтэй суралцуулан рагбигийн тамирчин болгож өсвөрийн шигшээ багаас эхлэн насанд хүрэгчдийн шигшээ багийн ахлагч болсон Дэлхийн рагбигийн шилдэг тамирчин юм.

Мөн энэ үеэр Япон улсад суралцах болсон Д.Норовсамбуугийн баримтат киног МРХ-ны Медиа менежер Б.Жаргалсайхан хийж үзэгчдэд хүргэлээ.



9 дэх удаагийн ДАШТ-ий нээлтэнд МРХ-ны зочид оролцлоо

ДАШТ-ний нээлтийн арга хэмжээнд тамирчдаа оролцуулав



ДАШТ-ий зохион байгуулах хорооноос Ази тивийн улс орнуудад 17-18 насны рагбигийн залуу тамирчдыг ДАШТ-ий нээлтэд оролцуулах сайхан боломжийг олгосон билээ. Бид энэхүү боломжийг рагбигаар хичээллэгч залуусын дунд нээлттэй Эссэ бичлэгийн уралдаан зарлаж сонгон шалгаруулалтаа хийсэн. Хөх Толбот Дайчид РК-ын Н.Байгальзул, Ирвэсүүд РК-ын Б.Ариунбаяр нарын Эссэ бичлэг шалгарч 9 дэх удаагийн ДАШТ-ий нээлтийн Япон-ОХУ-ын тоглолтыг үзсэн юм.



Н.Байгальзул, Б.Ариунбаяр нар АРХ-ны Ерөнхийлөгч асан Кoji Токумасугийн хамт

ДАШТ-ийг SPS TV-ээр шууд дамжуулан хүргэлээ

ДАШТ-ийг SPS TV-ээр Монгол улсад 3 удаагаа шууд дамжуулан үзүүлж, рагбигаар хичээллэгч болон нийт үзэгчдэд хүргэлээ.

Манай холбоо нь шууд дамжуулалтын тайлбарыг хийж, азтай үзэгч шалгаруулах зэрэг олон арга хэмжээг хийсэн байна.





Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, МҮОХ, 104 тоот



Утас: 9999-3639, 8805-8110, 8900-7655



Имэйл: austin.gansukh@mrfu.mn
enkh-amgalan@mrfu.mn
zagdsuren@mrfu.mn



www.mrfu.mn

Facebook page/MongolianRugby

Youtube/MongolianRFU

Instagram/MongoliaRugbyUnion

